

**ПАРИСЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ
ШВЕЙЦАРЫН ХОЛБООНЫ ЗӨВЛӨЛ БОЛОН
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

ШВЕЙЦАРЫН ХОЛБООНЫ ЗӨВЛӨЛ болон **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**
(цаашид хамтад нь “Талууд”, тус тусад нь “Тал” гэх),

Талуудын хоорондын найрсаг харилцааг **харгалзан үзэж**,

Талуудын найрсаг харилцаа болон үр өгөөжтэй хамтын ажиллагааг цаашид улам бэхжүүлэхийг **эрмэлзэн**;

Талуудын Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрэм болон Хүний эрхийн түгээмэл тунхаглал зэрэг олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд нийцүүлэн ардчилал, эрх зүйт ёс, хүний эрх, үндсэн эрхийг хүндэтгэх амлалтыг **дахин нотолж**;

2015 оны 12 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан Парисын Хэлэлцээр болон тус Хэлэлцээрийн 4, 6, 13 дугаар зүйл болон Парисын хэлэлцээрийн хүрээнд гарсан холбогдох шийдвэрүүдийг **эргэн санаж**;

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилгуудыг **эргэн санаж**;

Парисын Хэлэлцээрийн 4.1 дүгээр зүйл болон Уур амьсгалын өөрчлөлтийн талаар Засгийн газар хоорондын хороо (IPCC)-ны гаргасан аж үйлдвэржилтийн өмнөх үеэс дэлхийн дулаарал 1.5 хэмээр өссөнөөс үүдэж буй нөлөөллийн тухай тусгай тайлан болон дэлхийн хүлэмжийн хийн ялгарлын төлөвийн талаарх дүгнэлтэд үндэслэн 2050 он гэхэд дэлхий нийтээр хүлэмжийн хийн ялгарлыг цэвэр тэг түвшинд хүргэх шаардлагатайг **онцлон тэмдэглэж**;

Парисын Хэлэлцээрийн 4.19 дүгээр зүйлийн дагуу хүлэмжийн хийн ялгарал багатай урт хугацааны хөгжлийн стратегийг боловсруулж, Парисын хэлэлцээрийн Нарийн бичгийн дарга нарын газарт мэдээлэхийн ач холбогдлыг **эргэн санаж**;

Парисын Хэлэлцээрийн 6.2 дугаар зүйлийн хүрээнд хэрэгжих хамтын ажиллагаа нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах болон дасан зохицох арга хэмжээнд илүү өндөр түвшний зорилт тавих боломжийг бүрдүүлэхийг **тэмдэглэн**;

Ил тод байдлыг хангах, давхар тооллогоос урьдчилан сэргийлэх, байгаль орчныг хамгаалах, хүний эрхийг хүндэтгэх зарчимд тулгуурласан тогтвортой хөгжлийг дэмжих үүрэг, амлалтаа **дахин баталгаажуулж**;

Парисын Хэлэлцээрийн хүрээнд Швейцарын Холбооны Улсын хүчин төгөлдөр Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмэр нь олон улсын хэмжээнд шилжүүлсэн хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнг ашиглах зохицуулалт тусгасныг **хүлээн зөвшөөрч**;

Монгол Улс хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнг олон улсын хэмжээнд шилжүүлэх боломжийг Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтэд саад учруулахгүй байх нөхцөлтэйгөөр авч үзэж байгааг **тэмдэглэж**;

Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд Талууд тус бүр “Шилжүүлэгч” болон “Хүлээн авагч”-ийн үүргийг гүйцэтгэж болохыг **тэмдэглэн**;

Парисын Хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хамтын ажиллагааны арга хэлбэрийн талаарх удирдамжийг Парисын хэлэлцээрийн Талуудын 3 дугаар бага хурлаар баталсныг **харгалзан үзэж**;

П.С. дараах байдлаар харилцан тохиролцов:

Нэгдүгээр зүйл.Нэр томьёоны ерөнхий тодорхойлолт

Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд дараах нэр томьёог дор дурдсанаар ойлгож хэрэглэнэ:

1. “Хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүн” гэж Парисын хэлэлцээрийн 6.2 дугаар зүйлийн хүрээнд баталсан удирдамжийн шалгуурыг хангасан бөгөөд Парисын хэлэлцээрийн 4.13 дугаар зүйлд заасны дагуу баталсан арга аргачлал, хэмжүүрийг баримтлан хэмжсэн CO₂e-ийн нэг (1) метрик тонн нэгжээр илэрхийлэгдсэн хүлэмжийн хийн ялгарлын бууралт эсхүл шингээлтийг ойлгоно;

2. “Олон улсад шилжүүлэн тооцох хүлэмжийн хийн ялгарлын бууралт” (цаашид “ITMO” гэх) гэж Парисын хэлэлцээрийн 6.3 дугаар зүйлд заасны дагуу талуудын аль нэг талаас зөвшөөрөл олгосон хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнг ойлгох бөгөөд энэхүү Хэлэлцээрийн 9 дүгээр зүйл болон Парисын хэлэлцээрийн 6.2 дугаар зүйлийн хүрээнд баталсан удирдамжид нийцүүлэн Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмэр эсхүл олон улсад хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бусад зорилгоор ашиглахыг зөвшөөрч, шилжүүлсэн хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнг ойлгоно;

3. “Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмэр” (цаашид “NDC” гэх) гэж энэхүү Хэлэлцээрийн хүрээнд Парисын хэлэлцээрийн 4 дүгээр зүйлд заасны дагуу талууд тус бүр албан ёсоор мэдүүлсэн уур амьсгалын зорилтыг ойлгоно;

4. “Хүлээн авагч байгууллага” гэж талуудын тогтоосон журам болон Парисын хэлэлцээрийн 6.2 дугаар зүйлийн хүрээнд баталсан удирдамжид нийцүүлэн энэхүү Хэлэлцээрийн дагуу зөвшөөрөл олгосон олон улсад шилжүүлэн тооцох хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг хүлээн авдаг эрх бүхий хуулийн этгээдийг хэлнэ;

5. “Зөвшөөрөл” гэж Парисын хэлэлцээрийн 6.3 дугаар зүйл болон энэхүү Хэлэлцээрийн хүрээнд талууд тус бүр хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагаа болон түүнээс үүссэн хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнд олгосон зөвшөөрлийг баталгаажуулж олон нийтэд ил тод, албан ёсоор гаргасан мэдэгдлийг хэлэх бөгөөд энэхүү Хэлэлцээр болон Парисын хэлэлцээрийн 6.2 дугаар зүйлийн хүрээнд баталсан удирдамжийн дагуу холбогдох бүх шаардлагыг бүрэн хангах нөхцөлтэйгөөр Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтын биелэлт эсхүл олон улсад хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бусад зорилгоор ашиглах зөвшөөрлийг ойлгоно;

6. “Холбогдох зохицуулалт” гэж Парисын хэлэлцээрийн 4.13, 6.2 болон 13.7(b) дугаар зүйлд нийцүүлэн олон улсад шилжүүлэн тооцох хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг давхар тоолохоос урьдчилан сэргийлэх зорилгоор Парисын хэлэлцээрийн 6.2 болон 13.7(b) дугаар зүйлд заасны дагуу талууд тус бүр өөрийн үндэсний тайланд ашиглах нягтлан бодох бүртгэлийн тохируулгыг ойлгоно;

7. “Шилжүүлэх эрх бүхий байгууллага” гэж энэхүү Хэлэлцээрийн дагуу зөвшөөрөл олгосон хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнг шилжүүлэх эрхийг Шилжүүлэгч талаас олгосон хуулийн этгээдийг ойлгоно;

8. “Олголт” гэж энэхүү Хэлэлцээрийн дагуу талуудын тогтоосон журмын дагуу хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнг Бүртгэлийн системд шилжүүлэх боломжтой нэгж хэлбэрээр үүсгэж бүртгэхийг хэлнэ;

9. “Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагаа” гэж хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилго бүхий төсөл, хөтөлбөрийг ойлгоно;

10. "Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагааны загвар баримт бичиг" (цаашид "MADD" гэх) гэж хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагааг бүрэн тодорхойлсон албан ёсны баримт бичиг бөгөөд үйл ажиллагааны зорилго, суурь нөхцөл байдал, ашиглах стандарт ба аргачлал, хяналт-шинжилгээ болон баталгаажуулалтын шаардлага, кредит олгох хугацаа, Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн биелэлтийн хамрах хугацаа, үүсэх хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнгийн тоо хэмжээ, үнэлгээ болон зөвшөөрөл олгох зорилгоор талуудын шаардсан бусад мэдээллийг тусгана;

11. "Хяналт-шинжилгээний тайлан" гэж энэхүү Хэлэлцээр болон Парисын хэлэлцээрийн 6.2 дугаар зүйлийн хүрээнд баталсан удирдамжид нийцүүлэн Шилжүүлэх эрх бүхий байгууллага боловсруулсан албан ёсны тайланг хэлнэ. Энэхүү тайланд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагааны хэрэгжилтийг баталгаажуулахад шаардлагатай баталгаажихуйц өгөгдөл, хяналт шинжилгээний үзүүлэлтүүд, тооцоолсон хүлэмжийн хийн ялгарлын бууралтын эсхүл шингээлт болон батлагдсан аргачлалын хэрэгжилт багтана;

12. "Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийн хугацаа" гэж Парисын хэлэлцээрийн 4 дүгээр зүйлд заасны дагуу талууд тус бүр Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрээ хэрэгжүүлж, түүний биелэлтийг тооцон тайлагнадаг хугацааг хэлнэ;

13. "Олон улсад хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бусад зорилго" гэж Парисын хэлэлцээрийн хүрээнд Талуудын гуравдугаар бага хурлаар баталсан 2/CMA.3 дугаар шийдвэрт заасан Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг биелүүлэхээс бусад хүлэмжийн хийн ялгарлын бууралтын зорилгыг ойлгоно;

14. "Шилжүүлэлтийг хүлээн зөвшөөрөх" гэж энэхүү Хэлэлцээр болон Парисын хэлэлцээрийн 6.2 дугаар зүйлийн хүрээнд баталсан удирдамжид нийцүүлэн шинэ нэгж олголт хийхгүйгээр хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнг олон улсад шилжүүлэн тооцох хүлэмжийн хийн ялгарлын бууралт хэлбэрээр Бүртгэлийн системдээ бүртгэл хийхийг ойлгоно;

15. "Бүртгэлийн систем" гэж хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнг бүртгэж, хөтлөх цахим системийг хэлнэ;

16. "Хүлээн авагч тал" гэж энэхүү Хэлэлцээрийн дагуу олон улсад шилжүүлсэн хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнг Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн хүрээнд баталсан удирдамжид нийцүүлэн өөрийн Бүртгэлийн системд олон улсад шилжүүлэн тооцох хүлэмжийн хийн ялгарлын бууралт хэлбэрээр бүртгэж, баталгаажуулдаг талыг хэлнэ;

17. "Шилжүүлэгч тал" гэж Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн хүрээнд баталсан удирдамжид нийцүүлэн энэхүү Хэлэлцээрийн дагуу хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнгийн шилжүүлэлтийг зөвшөөрч, өөрийн Бүртгэлийн системдээ бүртгэн Үндэсний хэмжээнд тодорхойлсон нэмрийн хамрах хүрээнд тооцогдох ялгарлын түвшинд нэмэгдэл хэлбэрээр холбогдох зохицуулалтыг хийдэг талыг хэлнэ;

18. "Баталгаажуулагч" гэж хяналт-шинжилгээний тайланг баталгаажуулдаг хараат бус гуравдагч этгээдийг хэлнэ;

19. "Баталгаажуулалтын тайлан" гэж Баталгаажуулагчийн боловсруулсан хяналт-шинжилгээний тайлангийн үнэн зөвийг баталгаажуулж гаргасан албан ёсны тайланг хэлнэ;

20. "Олголт хийсэн он" гэж Парисын хэлэлцээрийн 6.2 дугаар зүйлийн хүрээнд баталсан удирдамжийн дагуу зөвшөөрөл олгох, шилжүүлэх болон тооцох зорилгоор

тайлагнах үед хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүн бодитоор олгосон календарь жилийг ойлгоно.

Хоёрдугаар зүйл.Зорилго

Энэхүү Хэлэлцээрийн зорилго нь Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлд нийцүүлэн Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг биелүүлэх эсхүл олон улсад хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бусад зорилгоор ашиглах хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг олон улсад шилжүүлэх эрх зүйн зохицуулалтын хүрээг тогтооход оршино. Энэ хүрээнд талууд тогтвортой хөгжлийг дэмжиж, байгаль орчны цогц байдлыг ханган, засаглалын ил тод байдлыг баталгаажуулж, давхар тооллого хийхээс урьдчилан сэргийлэх бүртгэн тооцох тогтолцоог бий болгоно.

Гуравдугаар зүйл.Эрх бүхий байгууллага

1.Монгол Улсын Засгийн газар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам болон түүний эрх залгамжлагч байгууллагаар дамжуулан энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлнэ.

2.Швейцарын Холбооны Улс Холбооны Байгаль орчны газар (FOEN)-аар дамжуулан Холбооны Байгаль орчин, тээвэр, эрчим хүч ба харилцаа холбооны яам болон түүний эрх залгамжлагч байгууллага нь энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлнэ.

Дөрөвдүгээр зүйл.Байгаль орчны цогц байдал

1.Талууд энэхүү Хэлэлцээрийн дагуу шилжүүлэх болон ашиглах боломжтой хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүн нь байгаль орчны цогц байдлыг хангахын тулд үндсэн зарчим болон доод шалгуурыг дараах байдлаар тогтооно:

1.1.Хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүн нь бодит, баталгаажсан, ердийн нөхцөлд гарахаас давсан нэмэлт үр дүнтэй, байнгын эсхүл байнгын байдлыг хангах тогтолцооны хүрээнд хэрэгжсэн байх ёстой. Мөн материаллаг буцаалт гарсан тохиолдолд зохих нөхөн олговроор залруулгыг хийнэ;

1.2.Хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүн нь 2021 оноос хойш бий болсон хүлэмжийн хийн ялгарлын бууралт эсхүл шингээлтийг илэрхийлсэн байх ёстой;

1.3.Хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнгийн олголт хийсэн он болон түүний ашиглалт нь нэгэн ижил Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийн хугацаанд багтах ёстой; болон

1.4.Хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүн дараах шаардлагыг хангасан үйл ажиллагаанаас үүссэн байх ёстой:

- a.дэлхийн нийт хүлэмжийн хийн ялгарлыг нэмэгдүүлэхгүй байх;
- b.талууд тус бүрийн хүлэмжийн хийн ялгарал багатай урт хугацааны хөгжлийн стратегитай нийцсэн байх;
- c.одоо хүчин төгөлдөр үйлчилж буй эсхүл батлуулахаар төлөвлөж буй бүх үндэсний бодлого, хууль тогтоомжийг харгалзан үзсэн байх;
- d.2050 он гэхэд нүүрстөрөгчийн ялгарлыг цэвэр тэг түвшинд хүрэх зорилттой нийцүүлэн хүлэмжийн хийн бага ялгарлын хөгжилд шилжих шилжилтийг хөхиүлэн дэмжих;
- e.цөмийн эрчим хүчний үйлдвэрлэлд суурилсан үйл ажиллагааг хамруулахгүй бөгөөд Парисын хэлэлцээрийн урт хугацааны зорилтуудтай үл нийцэх байдлаар хүлэмжийн хийн ялгарлыг тогтоон барьдаг үйл ажиллагаа болох чулуужсан түлшийг тасралтгүй ашиглахад тулгуурласан аливаа үйл ажиллагаа,технологи

болон өндөр ялгаруулалттай дадал хэвшлийг урт хугацаанд ашиглахаас зайлсхийсэн байх;
f.уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг арга хэмжээг эрчимжүүлэхийг дэмжиж, оролцогч талуудын үр нөлөө багатай оролцоог урамшуулах сэдэл бий болохоос сэргийлэх;
g.нүүрстөрөгчийн алдагдлын эрсдэлийг бууруулах;
h.суурь түвшинг тогтоохдоо консерватив хандлагыг баримталж, хүлэмжийн хийн ялгарлын өсөлтийн төсөөллийн доод түвшинг харгалзан үзэх;
i.Шилжүүлэгч талаас уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг арга хэмжээг эрчимжүүлэхэд урамшуулал болох бусад хүчин зүйлсийг харгалзан үзэх;
j.шаардлагатай тохиолдолд хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнг санхүүгийн эх үүсвэрт холбох;
k.агаарын чанар, биологийн олон янз байдалд үзүүлэх сөрөг нөлөөлөл, нийгмийн тэгш байдал, нас, хүйс, үндэс угсаанд үндэслэн хүн амын бүлгүүдийг ялгаварлан гадуурхах зэрэг байгаль орчны болон нийгмийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх.

Тавдугаар зүйл.Тогтвортой хөгжил

Шилжүүлэх болон ашиглахыг зөвшөөрсөн хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүн нь дараах шаардлагыг хангасан үйл ажиллагаанаас үүссэн байна. Үүнд:

- 1.Тогтвортой хөгжилд эерэг хувь нэмэр оруулах;
- 2.Тогтвортой хөгжлийн зарчимтай уялдсан, Парисын хэлэлцээрийн 6.1 дүгээр зүйлд заасны дагуу талуудын холбогдох үндэсний, бүс нутгийн болон олон улсын стратеги, бодлоготой нийцсэн байх;
- 3.Хүлэмжийн хийн ялгарал багатай урт хугацааны хөгжлийн стратегитай нийцэж, хүлэмжийн хийн бага ялгаруулалттай болон уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй хөгжлийг дэмжих;
- 4.Байгаль орчинд сөрөг нөлөөлөл учрахаас урьдчилан сэргийлж, холбогдох үндэсний болон олон улсын байгаль орчны хууль, дүрэм журам, стандартуудыг дагаж мөрдөх;
- 5.Нийгмийн зөрчилдөөн үүсгэхээс зайлсхийж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилгуудтай нийцүүлэн олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийг хүндэтгэн, холбогдох бүх оролцогч талуудын оролцоог хангана.
Талууд тус бүр өөрийн тогтолцооны хүрээнд үндэсний хэмжээнд тодорхойлсон тогтвортой хөгжлийн нэмэлт шалгуурыг хэрэгжүүлж болох бөгөөд энэ талаар нөгөө талдаа мэдэгдэнэ.

Зургаадугаар зүйл.Зөвшөөрөл олгох

1.Парисын хэлэлцээрийн 6.3 дугаар зүйл, энэхүү Хэлэлцээрийн 4 болон 5 дугаар зүйл болон талуудын холбогдох үндэсний шаардлагуудын хүрээнд Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг биелүүлэх эсхүл олон улсад хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бусад зорилгоор хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнг олон улсад шилжүүлэх, ашиглахад талууд тус бүрээс зөвшөөрөл авах шаардлагатай.

2.Талууд тус бүр байгууллагуудаас хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагаа болон түүний үр дүнд үүсэх хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнг олон улсад шилжүүлэх, ашиглах хүсэлтийг хүлээн авч, зөвшөөрөл олгохтой холбоотой журмыг боловсруулж, өөрийн үндэсний шаардлагад нийцүүлэн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах

үйл ажиллагааны загвар баримт бичгийг нийтэлнэ. Талууд тус бүр тухайн шаардлагад оруулсан аливаа өөрчлөлтийн талаар нөгөө талдаа мэдэгдэнэ.

3.Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох болон тухайн үйл ажиллагаанаас үүсэх хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнг олон улсад шилжүүлэх, ашиглахад зөвшөөрөл олгох нь тус тусдаа эрх зүйн үйлдэлд тооцогдоно. Хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнг олон улсад шилжүүлж, ашиглахад олгох зөвшөөрлийг хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагаанд олгох зөвшөөрлийн хамт нэгэн зэрэг нэг удаа олгож болно эсхүл энэхүү Хэлэлцээрийн 8 дугаар зүйлд заасан хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнг шилжүүлэх шаардлагыг бүрэн хангагдсаны дараа хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх хугацаанд давтан (тогтмол) байдлаар олгож болно.

4.Зөвшөөрөл олгосон хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагаанаас үүсэх хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнг энэхүү Хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу олон улсад шилжүүлж, ашиглахад зөвшөөрөл олгох бөгөөд уг зөвшөөрөл нь энэхүү Хэлэлцээрийн 8 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

5.Талууд тус бүр энэхүү Хэлэлцээрийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тодорхойлсон Бүртгэлийн системд олгосон зөвшөөрөл болон хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагааны загвар баримт бичгийг англи хэлээр нийтэлж, олгосон зөвшөөрөлд оруулсан нэмэлт өөрчлөлтийг энэхүү Хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу нөгөө талдаа мэдэгдэнэ.

6.Талууд тус бүр олгосон зөвшөөрлийг Парисын хэлэлцээрийн Нарийн бичгийн дарга нарын газар эсхүл Талуудын бага хурлаас гарсан холбогдох шийдвэрээр тодорхойлсон эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

7.Талууд тус бүр өөрийн олгосон зөвшөөрлүүд хоорондын нийцлийг шалгаж, зөрүү илэрсэн тохиолдолд албан ёсны мэдэгдлийг нийтэлж болно. Ийм мэдэгдэл хийгээгүй тохиолдолд талуудын аль аль талын олгосон зөвшөөрөл нийтлэгдсэн өдрөөс хойш гуч (30) хоногийн дараа энэхүү Хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагаанд олгосон зөвшөөрөл болон 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөвшөөрөл олгосон хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагаанаас үүссэн хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнг олон улсад шилжүүлж ашиглахыг зөвшөөрсөнд тооцно.

8.Шилжүүлэх эрх бүхий байгууллагын хүсэлтийн дагуу талууд тус бүр энэхүү зүйлд заасан журмын дагуу олгосон зөвшөөрлийг шинэчлэх эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Ийм шинэчлэлт, нэмэлт, өөрчлөлтийг Бүртгэлийн системд нийтэлж, нөгөө талдаа мэдэгдэх бөгөөд энэхүү Хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу нийцлийг шалгах ажиллагаа дуусгасны дараа хүчин төгөлдөр болно.

Долоодугаар зүйл.Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагааны загвар баримт бичиг

1.Зөвшөөрөл олгосон мэдэгдэл нь хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнгийн эх үүсвэр болох хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагаанд олгох зөвшөөрөл болон хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнг олон улсад шилжүүлж, ашиглах зөвшөөрлийг хамарна.

2.Энэхүү Хэлэлцээрт заасны дагуу хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнгийн эх үүсвэр болох хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагаанд олгосон зөвшөөрөл нь дор дурдсан мэдээллийг заавал агуулсан байна. Үүнд:

17.5.

20

- а. хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнгийн эх үүсвэр болсон хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагааг тодорхойлж, суурь баримт бичиг болох хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагааны загвар баримт бичгийн мэдээллийг хавсарган байх;
- б. ашигласан стандарт эсхүл суурь аргачлал, хяналт-шинжилгээ баталгаажуулалтын тайланд тавигдах шаардлагыг тодорхойлсон байх;
- с. хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагаанд хамаарах кредит олгох хугацааг тодорхойлсон байх;
- д. олон улсад шилжүүлэн тооцох хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг ашиглах зөвшөөрөл олгосон Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийн хугацааг шаардлагатай тохиолдолд тодорхойлсон байх;
- е. талуудын харгалзах зөвшөөрөлд хийсэн лавлагааг шаардлагатай тохиолдолд тусгасан байх;
- ф. Шилжүүлэгч талаас мэдүүлсэн хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнгийн хэмжээг заасан лавлагааг шаардлагатай тохиолдолд тусгасан байх;
- г. Шилжүүлэх эрх бүхий байгууллагыг тодорхойлсон байх. (Шилжүүлэгч талаас зөвшөөрөл олгосон тохиолдолд)

3. Хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнг олон улсад шилжүүлж, ашиглахад олгох зөвшөөрөл нь олон улсад шилжүүлэн тооцох хүлэмжийн хийн ялгарлын бууралтын зөвшөөрөгдсөн хэмжээг тодорхойлсон байх бөгөөд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагаанд хамаарах дээд хэмжээгээр эсхүл тогтсон давтамжаар олгодог хэмжээгээр илэрхийлэгдэж болно.

Наймдугаар зүйл. Хяналт шинжилгээ баталгаажуулалтын тайлан

1. Энэхүү Хэлэлцээрийн дагуу олон улсад шилжүүлэн тооцох хүлэмжийн хийн ялгарлын бууралт үүсэж зөвшөөрөл олгосон хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагаа бүрт холбогдох хяналт-шинжилгээ баталгаажуулалтын тайланг шаардана. Талууд тус бүр зөвшөөрсөн бөгөөд Шилжүүлэх эрх бүхий байгууллагаас сонгогдсон Баталгаажуулагч нь баталгаажуулалтын тайланг боловсруулж, хяналт-шинжилгээ баталгаажуулалтын тайланг талууд тус бүрт хүргүүлнэ.

2. Талууд тус бүр зөвшөөрсөн Баталгаажуулагчийн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй болгоно.

3. Талууд тус бүр хяналт-шинжилгээ баталгаажуулалтын тайланг олон нийтэд нээлттэй нийтэлж, тайлагнал нь Парисын хэлэлцээрийн 6.2 дугаар зүйлийн хүрээнд баталсан удирдамжтай нийцсэн байна.

4. Талууд тус бүр энэхүү Хэлэлцээрийн 7 дугаар зүйлийн 2(б) дэх заалтын дагуу олгосон зөвшөөрөлд тусгасан шаардлага болон Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн хүрээнд баталсан холбогдох удирдамжид нийцүүлэн хяналт-шинжилгээ баталгаажуулалтын тайланг үнэлнэ. Хяналт-шинжилгээ баталгаажуулалтын тайланг ирүүлсэн өдрөөс хойш ер (90) хоногийн дотор талуудын аль нэг тал нь бичгээр татгалзсан мэдэгдэл гаргаагүй тохиолдолд уг тайланг хүчин төгөлдөр гэж үзнэ.

5. Шилжүүлэгч тал нь Баталгаажуулагчийн хяналт-шинжилгээ баталгаажуулалтын тайланг ирүүлсэн өдрөөс хойш ер (90) хоногийн дотор шилжүүлэхийг зөвшөөрсөн хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүн нь дараах шилжүүлгийн шаардлагуудыг хангаж байгаа эсэхийг шалгана.

- а. хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнг ямар нэгэн өөр улсын үндэсний болон олон улсын тогтолцоо, зорилгын хүрээнд давхар тоолоогүй буюу давхар мэдүүлээгүй байх;

б.олгосон зөвшөөрлийн мэдэгдэлд заасан заалтуудтай зөрчилдөж буйг харуулах нотолгоо баримт байхгүй байх;
с.хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнд үүссэн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад хүний эрх зөрчсөн эсхүл Шилжүүлэгч талын дотоодын хууль тогтоомжийг зөрчсөн нотолгоо баримт байхгүй байх.

Шилжүүлэгч тал нь хянан шалгасан талаарх мэдэгдлийг олон нийтэд нээлттэйгээр нийтэлж, Хүлээн авагч тал болон Шилжүүлэх эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

6.Шилжүүлэгч талаас эерэг дүгнэлт гаргасан тохиолдолд Хүлээн авагч тал нь шилжүүлгийн шаардлагыг хангасныг баталгаажуулсан мэдэгдлийг гуч (30) хоногийн дотор гаргана. Хүлээн авагч тал нь уг баталгаажуулсан мэдэгдлийг олон нийтэд нээлттэй нийтэлж, Шилжүүлэгч тал болон Шилжүүлэх эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

Есдүгээр зүйл.Шилжүүлгийг хүлээн зөвшөөрөх

Талууд тус бүр энэхүү Хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн 5 болон 6 дахь хэсэгт заасны дагуу эерэг дүгнэлт болон баталгаажуулсан мэдэгдэл гаргасан хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнгийн шилжүүлгийг хүчинтэй гэж хүлээн зөвшөөрнө. Үүнд:

1. Шилжүүлэх эрх бүхий байгууллагын хүсэлтийн дагуу Шилжүүлэгч тал нь шилжүүлгийн тухай Хүлээн авагч байгууллага болон Хүлээн авагч талд уг шилжүүлгийн талаар мэдэгдэнэ. Ийм мэдэгдэлд дараах мэдээллийг багтаана. Үүнд:

- а.Хүлээн авагч байгууллагын тодорхойлолт;
- б.шилжүүлсэн хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнгийн хэмжээний талаарх мэдээлэл;
- с.хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүн бүрийн өвөрмөц таних дугаар, хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнгийн гарал үүсэл болон олголт хийсэн оны талаарх мэдээлэл;
- д.энэхүү Хэлэлцээрийн 11 дүгээр зүйлд заасны дагуу холбогдох зохицуулалт хийхэд ашиглах аргачлал;
- е.энэхүү Хэлэлцээрийн 7 дугаар зүйлд заасны дагуу олгосон зөвшөөрөлд хийсэн лавлагаа.

2.Шилжүүлэгч тал нь энэхүү Хэлэлцээрийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тодорхойлсон Бүртгэлийн системд хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнгийн шилжүүлгийг бүртгэж, хүлээн зөвшөөрөх бөгөөд 11 дүгээр зүйлд заасны дагуу шаардлагатай холбогдох зохицуулалтыг хийнэ.

3.Хүлээн авагч тал энэхүү Хэлэлцээрийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тодорхойлсон Бүртгэлийн системд шилжүүлэгдсэн хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнг олон улсад шилжүүлэн тооцох хүлэмжийн хийн ялгарлын бууралт болгон бүртгэж, хүлээн зөвшөөрнө.

Аравдугаар зүйл.Бүртгэл

1.Талууд тус бүр энэхүү Хэлэлцээрийн дагуу хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүн болон олон улсад шилжүүлэн тооцох хүлэмжийн хийн ялгарлын бууралтад зөвшөөрөл олгох, бүртгэх зорилгоор дараах шаардлагыг хангасан Бүртгэлийн системийг тодорхойлж, ашиглана. Үүнд:

- а.Бүртгэлийн систем нь олон нийтэд нээлттэй, ил тод, мэдээллийн аюулгүй байдлыг хангана;

б.энэхүү Хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу зөвшөөрлийг нийтэлсний дараа 9 дүгээр зүйлийн 2 болон 3 дахь хэсэгт заасны дагуу шилжүүлэгт олгосон зөвшөөрөлд үндэслэн Бүртгэл системийг шинэчилнэ;

с.Бүртгэлийн систем нь энэхүү Хэлэлцээрийн дагуу зөвшөөрөл олгогдсон олон улсад шилжүүлэн тооцох хүлэмжийн хийн ялгарлын бууралтад зориулсан давтагдашгүй таних дугаар, гарал үүсэл, олголт хийсэн оны мэдээлэл болон зөвшөөрөлд хийсэн лавлагаа, хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнгийн шилжүүлгийг хүлээн зөвшөөрөхөд шаардагдах баримт бичиг зэргийг агуулна.

2.Талууд олон улсад шилжүүлэн тооцох хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг шилжүүлэх, зөвшөөрөл олгох, цуцлах болон бүртгэх зорилгоор хамтарсан Бүртгэлийн системийг тодорхойлон ашиглаж болно. Хамтарсан Бүртгэлийн систем нь энэхүү Хэлэлцээрийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.

Арваннэгдүгээр зүйл.Холбогдох зохицуулалт

Энэхүү Хэлэлцээрийн дагуу зөвшөөрөл олгосон олон улсад шилжүүлэн тооцох хүлэмжийн хийн ялгарлын бууралтад давхар тооллого хийхээс урьдчилан сэргийлэхийн тулд талууд тус бүр Парисын хэлэлцээрийн 6.2 дугаар зүйл болон бусад холбогдох зүйлийн хүрээнд баталсан удирдамжид нийцүүлэн холбогдох зохицуулалтыг хэрэгжүүлнэ.

Арванхоёрдугаар зүйл.Тайлагналт

Талууд тус бүр энэхүү Хэлэлцээрийн хэрэгжилттэй холбоотой мэдээллийг Парисын хэлэлцээрийн 6.2 дугаар зүйлийн хүрээнд баталсан удирдамжид нийцүүлэн Парисын хэлэлцээрийн Нарийн бичгийн дарга нарын газарт тайлагнана.

Арвангуравдугаар зүйл.Олон улсын уур амьсгалын санхүүжилтэд давхар тооллого хийхгүй

Энэхүү Хэлэлцээрийн дагуу зөвшөөрөл олгосон олон улсад шилжүүлэн тооцох хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг худалдан авахад ашигласан санхүүгийн болон бусад нөөцийг Парисын хэлэлцээрийн 9, 10 болон 11 дүгээр зүйлд заасны дагуу олгосон буюу татан төвлөрүүлсэн дэмжлэг гэж тооцон тайлагнахгүй. Харин энэхүү Хэлэлцээрийн талууд Парисын хэлэлцээрийн 13.13 дугаар зүйлд нийцүүлэн өөрөөр тохиролцсон тохиолдолд энэхүү журам хамаарахгүй.

Арвандөрөвдүгээр зүйл.Нийтлэг асуудал

1.Талууд авлигын эсрэг хамтын хүчин чармайлт гаргах талаар тохиролцож, ялангуяа энэхүү Хэлэлцээрийн дагуу олгосон зөвшөөрөл эсхүл шилжүүлэгт олгосон зөвшөөрлийг баталгаажуулах зорилгоор хэнд ч, шууд эсхүл шууд бусаар, ямар нэгэн хэлбэрийн санал, бэлэг, төлбөр, хөлс урамшуулал, ашиг өгөх үйлдлийг хууль бус үйлдэл эсхүл авлигын хэлбэр гэж үзнэ. Ийм төрлийн аливаа үйлдэл нь энэхүү Хэлэлцээрийн 20 дугаар зүйлд заасны дагуу шилжүүлэгт олгосон зөвшөөрлийг түдгэлзүүлэх хангалттай үндэслэл болно.

2.Талууд энэхүү Хэлэлцээрийн хэрэгжилттэй холбогдуулан үүссэн хууль бус үйлдэл эсхүл авлигын шинжтэй үйл ажиллагааны талаар үндэслэл бүхий сэжиг эсхүл нотолгоо гарсан даруйд нэг тал нөгөө талдаа нэн даруй мэдэгдэнэ.

Арвантавдугаар зүйл.Хамтарсан хороо

1.Талууд тус бүр энэхүү Хэлэлцээрийн 3 дугаар зүйлд тодорхойлсон эрх бүхий байгууллагуудаас томилсон төлөөлөгчдөөс бүрдэх Хамтарсан хороог байгуулна.

2.Энэхүү Хэлэлцээрийн 6, 7, 10, 11 болон 12 дугаар зүйлд заасан талууд тус бүрийн бүрэн эрхт байдлыг аливаа хэлбэрээр хязгаарлалгүйгээр Хамтарсан хороо нь энэхүү Хэлэлцээрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- а.энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх явцад үүсэж болзошгүй техникийн болон зохицуулалтын журамтай холбоотой асуудал болон энэхүү хэлэлцээрийг тайлбарлахтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;
- б.энэхүү Хэлэлцээрийн 6 ба 7 дугаар зүйлд заасан зөвшөөрөл олгох үйл явцтай холбоотойгоор Талуудын хооронд үл нийцэл гарсан тохиолдолд зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, тодруулга өгөх, заавал биелэгдэх шинжгүй зөвлөмж гаргах замаар зохицуулалтын механизмын үүрэг гүйцэтгэх;
- с.Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлд нийцүүлэн байгаль орчны цогц байдлыг хангахад зорилгоор талуудын хоорондын уялдаа холбоо, чиглүүлэг болон мэдээлэл солилцоог дэмжих;
- д.энэхүү Хэлэлцээрийн 12 дугаар зүйлд нийцүүлэн, тайлагналыг цаг хугацаанд нь, үнэн зөв бөгөөд ил тод байдлаар гаргахыг хангах зорилгоор талуудын хоорондын уялдаа холбоо, чиглүүлэг болон мэдээлэл солилцоог дэмжих;
- е.Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлтэй холбоотой чадавх бэхжүүлэх, техникийн туслалцаа үзүүлэх, мэдээлэл солилцох чиглэлээр талуудын хамтын ажиллагааг дэмжих;
- ф.энэхүү Хэлэлцээрийн хэрэгжилтийн явцыг бүхэлд нь үнэлж, шаардлагатай гэж үзвэл түүнтэй холбоотой асуудлаар талуудад зөвлөмж өгнө.

3.Энэхүү зүйлийн 2 дугаарт заасан үүрэг, чиг үүрэгтэй холбоотойгоор талуудын аль нэг тал нь хүсэлт гаргасан тохиолдолд Хамтарсан хороо хуралдана.

Арванзургаадугаар зүйл.Хүчин төгөлдөр болох болон үргэлжлэх хугацаа

1.Энэхүү Хэлэлцээр нь хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хойш жар (60) хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

2.Энэхүү Хэлэлцээр нь одоогийн Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийн хугацаа 2034 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дууссанаас хойш дөрвөн (4) жилийн хугацаанд хүчин төгөлдөр хэвээр байна.

3.Энэхүү Хэлэлцээр нь дараагийн Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийн үе шат бүрийн хугацаанд үргэлжлэн хүчин төгөлдөр байх бөгөөд талуудын аль нэг тал нь энэхүү Хэлэлцээрийн 19 дүгээр зүйлд заасны дагуу цуцлах тухай бичгээр мэдэгдэл хүргүүлсэн тохиолдолд сунгалт хийгдэхгүй.

Арвандолоодугаар зүйл.Нэмэлт, өөрчлөлт

Хэрэв Талууд өөрөөр тохиролцоогүй бол энэхүү Хэлэлцээрт оруулах аливаа нэмэлт, өөрчлөлт нь бичгээр хийгдэж, энэхүү Хэлэлцээрийн зүйл заалтыг тодорхойлон дурдсан байх бөгөөд энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсонтой адил журмаар хүчин төгөлдөр болно.

Арваннаймдугаар зүйл.Маргаан шийдвэрлэх

Энэхүү Хэлэлцээрийн тайлбар, хэрэгжилттэй холбоотой Талуудын хооронд үүссэн аливаа маргааныг дипломатын шугамаар шууд хэлэлцээ хийх замаар эв зүйгээр шийдвэрлэнэ.

Арванесдүгээр зүйл.Хэлэлцээрийг цуцлах

1.Аль нэг тал нь нөгөө талдаа бичгээр цуцлах мэдэгдэл хүргүүлж энэхүү Хэлэлцээрийг цуцалж болно. Хэлэлцээр цуцлах мэдэгдлийг хүргүүлэх үеийн Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийн хугацаа дууссанаас хойш дөрвөн (4) жилийн хугацаанд хүчин төгөлдөр хэвээр байна.

2.Шилжүүлэгч тал нь энэхүү хэлэлцээр дуусгавар болсныг Шилжүүлэх эрх бүхий байгууллагуудад нэн даруй мэдэгдэнэ.

Хорьдугаар зүйл.Шилжүүлгийг түдгэлзүүлэх

1. Талуудын аль нэг тал нь дараах тохиолдолд энэхүү Хэлэлцээрт заасны дагуу шилжүүлэг хийхэд олгох зөвшөөрлийг түдгэлзүүлж болно. Үүнд:

а.нөгөө тал нь Парисын хэлэлцээрийн 4.2 дугаар зүйлд заасан үүргээ биелүүлээгүй нь тогтоогдсон тохиолдолд уг асуудлыг Парисын хэлэлцээрийн 15 дугаар зүйлд заасны дагуу байгуулагдсан Хамтарсан хорооны холбогдох дүгнэлт, үнэлгээнд үндэслэн шийдвэрлэнэ.

б.нөгөө тал нь энэхүү Хэлэлцээрийн заалтуудыг ноцтой хэмжээнд зөрчсөн тохиолдолд;

с.байгаль орчны цогц байдалд сөргөөр нөлөөлөхүйц бодит ноцтой хэмжээнд худал эсхүл буруу мэдээлэлд үндэслэн зөвшөөрөл олгосон тохиолдолд.

2.Шилжүүлэг хийхэд олгох зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай мэдэгдлийг бичгээр нөгөө талдаа мэдэгдэнэ. Тус түдгэлзүүлэлт нь бичгээр мэдэгдлийг нөгөө тал хүлээн авснаас хойш гуч (30) хоногийн дараа эсхүл мэдэгдэлд огноо заасан тохиолдолд уг мэдэгдэлд заасан өдрөөс хойш хүчин төгөлдөр болно.

Хориннэгдүгээр зүйл.Хэлэлцээр дуусгавар болгох

1.Талуудын аль нэг тал нь Парисын хэлэлцээрээс гарсан тохиолдолд энэхүү Хэлэлцээр болон энэхүү Хэлэлцээрт үндэслэн олгосон бүх зөвшөөрөл дуусгавар болно.


2.Хэлэлцээр дуусгавар болгосон нь тухайн талын Парисын хэлэлцээрээс гарах тухай шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Хоёр талын Засгийн газраас зохих журмын дагуу эрх олгогдсон төлөөлөгчид энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурав.

Энэхүү хэлэлцээрийг Белем д. 2025 оны 11 сарын 20-ны өдөр англи, монгол болон герман хэлээр гурван эх хувь үйлдэв. Бүх хэл дээрх хувилбарууд нь адил хүчинтэй бөгөөд агуулгын хувьд зөрүү үүссэн тохиолдолд англи хэл дээрх хувилбарыг баримтална.


ШВЕЙЦАРЫН ХОЛБООНЫ ЗӨВЛӨЛИЙГ
ТӨЛӨӨЛӨН
Альберт Рёшти

Байгаль орчин, тээвэр, эрчим хүч,
харилцаа холбооны сайд, Холбооны
Канцлер


МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛӨН
Б.Батбаатар

Байгаль орчин, уур амьсгалын
өөрчлөлтийн сайд